



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөшөөт хөгжил сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/225/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэцэцэг
Утас: 99019943
Цахим хаяг: erdenetsetseg.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	13
3.5.3 Нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Залруулсан алдаа	16
5.2 Төлбөрийн акт	17
5.3 Албан шаардлага	17
5.4 Зөвлөмж	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХС	Хөшөөт хөгжил сан
ХШУДАГ	Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

1 ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХӨШӨӨТ ХӨГЖИЛ САНГИЙН
ДАРГА Т.МЯГМАРДОРЖ ТАНАА

2022.02.24 № 02/79
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөшөөт хөгжил сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөшөөт хөгжил сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтын зардлын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй анхан шатны баримтын бүрдүүлэлт, санхүүгийн тайлан гаргалт хангалтгүй, төсвийг зохистой үр ашигтай зарцуулаагүй, төрийн сангийн төлбөр тооцооны журам мөрдөөгүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 3 улирлын байдлаар 1.8 сая тонн нүүрс экспортлон гаргасан ба тонн тутмаас 1ам долларыг орон нутгийн Ховд Хөшөөт хөгжил санд 4.0 тэрбум төгрөг, Дарви суманд 852.2 сая төгрөг, Цэцэг суманд 852.2 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус төвлөрүүлэн хамтран ажилласан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ нь тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд ИТХ-ын төлөөлөгч нарыг мэргэшүүлэх, чадавхжуулах арга хэмжээнд 493.3 сая төгрөг, орон нутгийн өмчийн газруудыг дэмжих санхүүжилт 322.0 сая төгрөг баталж зарцуулсан байна.

021020179

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд хөрөнгө оруулалтын 6 зорилтын хүрээнд 3.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэн ажиллах, үлдэгдэл хөрөнгө оруулалтууд он дамжин хэрэгжихээр төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 2022 оны төлөвлөгөөг 74 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн байна.

Байгаль орчныг хамгаалах зардал 80.0 сая, Орон нутгийн хөгжил зорилтод түвшинд 364.4 сая, Боловсролын салбарт 163.4 сая, Эрүүл мэндийн салбарт 122.0 сая, Соёл, Спортын салбарт 183.1 сая, Дэд бүтэц сайжруулахад 1.8 тэрбум төгрөгийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>662,408,984.45</u>	<u>372,010,767.90</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	30,013,233.55	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	30,013,233.55	-
3121	Төгрөг	30,013,233.55	-
31211	Төрийн сангийн харилцах	30,013,233.55	-
33	АВЛАГА	627,351,200.90	94,668,287.90
33300	Татаас, санхүүжилтийн авлага	601,251,200.90	68,568,287.90
335	Бусад авлага	26,100,000.00	26,100,000.00
3351	Байгууллагаас авах авлага	26,100,000.00	26,100,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,733,900.00	274,031,830.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,733,900.00	274,031,830.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,310,650.00	3,310,650.00
354	Хангамжийн материал	3,310,650.00	3,310,650.00
35410	Бичиг хэргийн материал	969,050.00	969,050.00
35420	Аж ахуйн материал	2,341,600.00	2,341,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,207,219.70</u>	<u>5,951,789.59</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,207,219.70	5,951,789.59
392	Биет хөрөнгө	4,738,469.80	5,795,539.73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,979,800.00	12,779,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,336,149.92)	(8,606,099.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,499,900.00	4,499,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2,405,080.28)	(2,878,060.40)
393	Биет бус хөрөнгө	468,749.90	156,249.86
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(781,250.10)	(1,093,750.14)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>667,616,204.15</u>	<u>377,962,557.49</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>543,308,350.81</u>	<u>2,231,006.79</u>

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	543,308,350.81	2,231,006.79
413	Өглөг	543,308,350.81	2,231,006.79
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,209,317.42	2,226,906.79
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,100.00	4,100.00
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	204,714,874.00	-
4136	Бусад өглөг	336,380,059.39	-
41361	Байгууллагад төлөх өглөг	335,740,049.39	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	640,010.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>124,307,853.34</u>	<u>375,731,550.70</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	124,307,853.34	375,731,550.70
512	Хуримтлагдсан үр дүн	124,307,853.34	375,731,550.70
51210	Өмнөх үеийн үр дүн	124,307,853.34	132,629,209.73
51220	Тайлант үеийн үр дүн	-	243,102,340.97
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>667,616,204.15</u>	<u>377,962,557.49</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,706,033,977.00	4,009,576,044.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,706,033,977.00	4,009,576,044.42
120	Нийтлэг татварын бус орлого	1,706,033,977.00	4,009,576,044.42
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,706,033,977.00	4,009,576,044.42
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,706,033,977.00	4,008,765,724.42
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	810,320.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,708,029,648.06	3,766,473,703.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	52,368,687.06	963,707,155.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,868,687.06	106,025,862.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	29,559,870.00	42,219,908.00
210101	Үндсэн цалин	29,559,870.00	3,046,161.00
210102	Нэмэгдэл	-	39,173,747.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,378,303.71	5,527,388.55
210201	Тэтгэврийн даатгал	2,197,724.68	3,767,192.23

210202	Тэтгэмжийн даатгал	295,144.58	443,199.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	236,115.67	351,199.30
210204	Ажилгүйдлийн даатгал	59,029.62	87,799.78
210205	Эрүүл мэндийн даатгал	590,289.16	877,998.16
2104	Хангамж, бараа материалын зардал	3,979,200.00	4,014,456.00
210401	Бичиг хэрэг	793,000.00	1,310,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,868,000.00	2,299,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	229,000.00	354,956.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,200.00	50,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	26,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	949,700.00	2,226,000.00
210702	Дотоод албан томилолт	718,000.00	2,226,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	231,700.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,600,000.00	49,109,942.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	47,309,942.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	1,800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,401,613.35	2,928,168.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,500.00	873,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,267,113.35	2,055,168.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00	857,681,293.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	6,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00	6,750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	850,931,293.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	850,931,293.24
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,655,660,961.00	2,802,766,547.55
2200	Дотоод эх үүсвэрээр	1,655,660,961.00	2,802,766,547.55
220001	Барилга байгууламж	173,957,631.00	329,111,835.00
221001	Их засвар	292,847,535.00	82,297,533.00
222001	Тоног төхөөрөмж	181,091,397.00	639,033,990.25
223001	Бусад хөрөнгө	1,007,764,398.00	1,752,323,189.30

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(1,995,671.06)	243,102,340.97
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(1,995,671.06)	243,102,340.97

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,378,066,200.00</u>	<u>4,388,844,083.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,378,066,200.00	4,388,844,083.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,378,066,200.00	4,388,844,083.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,378,066,200.00	4,388,033,763.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,378,066,200.00	4,388,033,763.00
120009	Бусад орлого	-	810,320.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>51,505,215.33</u>	<u>919,583,156.72</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,505,215.33	919,583,156.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,005,215.33	61,901,863.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,752,715.33	43,060,179.11
210101	Үндсэн цалин	24,076,225.33	39,954,870.11
210102	Нэмэгдэл	1,855,937.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,820,553.00	1,526,000.00
210104	Урамшуулал	-	1,579,309.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,191,200.00	4,682,128.37
210201	Тэтгэврийн даатгал	2,949,300.00	3,028,628.35
210202	Тэтгэмжийн даатгал	310,500.00	461,065.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	248,400.00	101,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	62,100.00	241,834.81
210205	Эрүүл мэндийн даатгал	620,900.00	848,899.36
2104	Хангамж, бараа материалын зардал	3,009,500.00	3,654,456.00
210401	Бичиг хэрэг	770,000.00	660,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,818,000.00	2,299,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	222,000.00	354,956.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	199,500.00	340,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,451,900.00	1,492,100.00

210702	Дотоод албан томилолт	1,451,900.00	1,492,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,600,000.00	6,320,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	3,320,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,999,900.00	2,693,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,999,900.00	2,693,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00	857,681,293.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	6,750,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00	6,750,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	850,931,293.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	850,931,293.24
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,326,560,984.67</u>	<u>3,469,260,926.28</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,304,184,145.00	3,499,274,159.83
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,304,184,145.00	3,499,274,159.83
2200	Дотоод эх үүсвэрээр	1,304,184,145.00	3,499,274,159.83
220001	Барилга байгууламж	118,073,199.00	333,611,835.00
221001	Их засвар	286,345,172.00	88,879,569.00
222001	Тоног төхөөрөмж	103,629,897.00	642,724,990.25
223001	Бусад хөрөнгө	796,135,877.00	2,434,057,765.58
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,304,184,145.00)</u>	<u>(3,499,274,159.83)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,376,839.67	(30,013,233.55)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		30,013,233.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,013,233.55	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	117,803,262.40	117,803,262.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	117,803,262.40	117,803,262.40

C07	Тайлант үеийн үр дүн	6,504,328.94	6,504,328.94
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	124,307,591.34	124,307,591.34
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	124,307,591.34	124,307,591.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	8,321,618.39	8,321,618.39
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	132,629,209.73	132,629,209.73
D08	Тайлант үеийн үр дүн	243,102,340.97	243,102,340.97
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	375,731,550.70	375,731,550.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,737,100,000.00	3,157,834,431.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,769,400.00	68,769,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	61,269,400.00	62,269,400.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,857,200.00	42,436,508.00
210101	Үндсэн цалин	39,331,200.00	40,910,508.00
210102	Нэмэгдэл	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,526,000.00	1,526,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,107,200.00	6,126,092.00
210201	Тэтгэврийн даатгал	3,472,900.00	4,063,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	817,200.00	784,292.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	81,700.00	248,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	408,600.00	408,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	326,800.00	620,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,655,000.00	3,655,000.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	770,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,300,000.00	1,818,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	355,000.00	222,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	199,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,900,000.00	1,451,900.00
210702	Дотоод албан томилолт	1,900,000.00	1,451,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,600,000.00	6,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,500,000.00	3,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,150,000.00	1,999,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,150,000.00	1,999,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,500,000.00	6,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,500,000.00	6,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,500,000.00	6,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,668,330,600.00	3,089,065,031.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,668,330,600.00	3,089,065,031.00
220001	Барилга байгууламж	307,000,000.00	120,680,037.00
221001	Их засвар	2,034,200,000.00	268,215,795.00
222001	Тоног төхөөрөмж	632,700,000.00	422,555,690.00
223001	Бусад хөрөнгө	694,430,600.00	2,277,613,509.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,737,100,000.00	3,157,834,431.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,737,100,000.00	3,157,834,431.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,737,100,000.00	3,157,834,431.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		30,013,233.55
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3	3
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	2	2

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтээр орлого зарлагын гүйлгээ гараагүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөшөөт хөгжил сан нь Ховд аймгийн эдийн засаг нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж, нийгмийн салбарыг хөгжүүлэх байгаль орчныг хамгаалахад аймгийн нутаг дэвсгэрт баялаг ашиглагчдын нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм. Тус сан нь аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийг дэмжихээр дараах салбаруудын төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг байна. Үүнд :

- ✓ *Аймгийн болон нөлөөллийн сумдын дэд бүтцийн салбарын хөгжүүлэх.*
- ✓ *Үйлдвэрлэл, үйлчилгээ, Хөдөө аж ахуйн салбарын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих*
- ✓ *Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх*
- ✓ *Нийгэм соёлын салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх*
- ✓ *Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх*
- ✓ *Аймгийн ИТХ, Засаг даргаас дэмжсэн бусад асуудлууд*
- ✓ *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- ✓ *Хөшөөт хөгжил сангийн журмыг хэрэгжүүлэх*

ХХС-ийн орон тоог 2022 оны 01 дугаар сарын 03-ны өдрийн 01 тоот төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр 3 байхаар баталсан байна. ХХС нь удирдах 1, гүйцэтгэх албан тушаалтан 1, үйлчилгээний 1 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж батлагдсан орон тоогоор ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

✓ *Төрийн хэмнэлтийн тухай хууль*

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль Хөшөөт хөгжил сангийн журам зэрэг бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөгүй** байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн ажлаа сангийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа хөрөнгүүдийг үр ашигтай захиран зарцуулагдаж байгаа эсэхийг хянаж шалгах үүднээс жилд 4-5 удаа холбогдох байгууллагатай нь уулзаж санал бодлын солилцон хяналт тавин ажилладаг Мөн сангийн хөрөнгийг үнэгүйдүүлэхгүйн тулд Орон нутгийн өмчийн газартай хамтран ашиглагч байгууллагын данс бүртгэлд хөрөнгийг орлогоор бүртгүүлж Ховд Хөшөөт хөгжил сангийн пэйж хуудсанд зураг, видео хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мөн МоЭнКо ХХК-д сар сардаа гүйцэтгэлийн тайлангаа танилцуулан ажиллаж байна гэж товч мэдээлэл ирүүлсэн.

Удирдах зөвлөл, аймгийн ИТХ, ХШҮДАГ, болон Санхүүгийн дотоод аудитын албанаас тус онд дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг хангалтгүй нөхцөл байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах **шаардлагагүй** гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөшөөт хөгжил сан нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад **нийцсэн** тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бодлогын баримт бичиг байхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөшөөт хөгжил сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 290.4 сая төгрөгөөр буюу 43.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	30,013.2	-	(30,013.2)
Авлага	629,085.1	367,889.8	(261,195.3)
Бараа материал	3,310.6	3,310.6	-
Үндсэн хөрөнгө	5,207.3	5,951.9	744.6
Нийт хөрөнгө	667,616.2	377,152.3	(290,463.9)
Өр төлбөр	543,308.4	2,218.4	(541,090.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	124,307.8	374,933.8	250,626.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	667,616.2	377,152.2	(290,464.0)

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ *Өмнөх оны үлдэгдлийг тайлант онд зарцуулж мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.*
- ✓ *Хөрөнгө оруулалтын зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлж татаас санхүүжилтийн авлагаар бүртгэн тайлант онд авч зарцуулсан байна. Оны эцэст авлагын дансанд 367.9 сая төгрөгийн авлага бүртгэсэн нь Мон Эн Ко ХХ-аас иргэдэд олгосон нүүрсний зөрүү 67.8 сая, хөрөнгө оруулалтын он дамжсан хөрөнгийн санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 274.0 сая, Илчит улаач ХХК-ны ажил гүйцэтгээгүй санхүүжилтийн авлага 26.1 сая төгрөгтэй холбоотой үүссэн байна.*
- ✓ *Тайлант онд үндсэн хөрөнгө данс 0.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тайлагнахад шинээр нэмж орлого авсан 2.8 сая төгрөгийн хөрөнгийн орлого, бүртгэлтэй хөрөнгүүдэд 2.1 сая төгрөгийн элэгдлийн тооцсон нь нөлөөлсөн байна.*

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Мон Эн Ко ХХК-тай байгуулсан гэрээний дагуу тайлант хугацаанд экспортолсон нүүрсний 1 тн тутмаас 0.7 ам. доллароор тооцож Хөшөөт хөгжил санд төвлөрүүлж зорилтод түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийг батлуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 5/07 тоот тогтоолын 5-р хавсралтаар Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний төсвийг 3358.3 сая төгрөгөөр, ХХС-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2002 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн 01 тоот шийдвэрээр үйл ажиллагааны зардлыг 68.8 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 2022.08.29-ны 8/03 тоот тогтоол, 2022.10.21-ы 9/07 тоот тогтоолоор 2 удаа нэршил өөрчилж баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 64 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3737.1 сая төгрөгийг экспортолсон нүүрсний тн тутмаас төвлөрүүлэх орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр экспортолсон нүүрсний орлогоос 4008.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж төсөвт 850.9 сая төгрөг буцаан төвлөрүүлж 3157.8 сая төгрөгийг зарцуулсан байна. Батлагдсан төсвөөс 271.6 сая төгрөгөөр орлого давуулан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 3157.8 сая төгрөг буюу 80.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 850.9 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106/80101-Зардал	3,500.0	2,501.9	998.1	71.5
2	70106/80802-Тэтгэвэр, тэтгэмж	7,500.0	6,750.0	750.0	90
3	70106/80918-Хөрөнгө оруулалт	3,726,100.0	2,876,916.8	849,183.2	77.2
ДҮН		3,737,100.0	2,886,168.7	850,931.3	80.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн санхүүжилтээр орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөшөөт хөгжил сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн авлагатай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор Д.Эрдэнэцэцэг 2023 оны 03 дүгээр сарын 18-наас 03 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1699.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 16.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 10.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 4135.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 41.4 сая төгрөгөөр тооцож төлөвлөлтийн шатны материаллаг байдлын 60 хувиар буюу 24.8 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 76 мэдээллээс хугацаандаа оруулсан 64 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 12, нийт 76 мэдээлэл бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь “Төр захиргааны нэгдсэн төвийг дулаанд холбох / Жаргалант сум”, Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудад дулааны тоолуур авах” ажлуудыг данс бүртгэлд тусгаж, төсвийн үр өгөөжийг дээшлүүлж ажилласан эсэхийг дахин хянаж үзэх шаардлагатай гэж үзсэн байна.

Өмнөх аудитаар нийт 451.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 204.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, үр өгөөжийг нэмэгдүүлэх 243,8 сая төгрөгийн 2 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,8 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн байгааг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1.0	-	-	-
Албан шаардлага	2	448.0	1	243.8	50
Зөвлөмж	1	18.1	1	18.1	100
Нийт дүн	4	467.1	2	261.9	75.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь Хөшөөт хөгжил сангийн орлого бүрдүүлэлт, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хэрэгжүүлэн хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтуудын үр дүнг нарийвчлан хянах шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 878.9 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс үр дүнгийн тайланд 0.8 сая, төсвийн гүйцэтгэлийн тайланд 431.3 сая, мөнгөн хөрөнгийн тайланд 21.2 сая, урьдчилж гарсан зардлын авлага 273.0 сая, өмнөх оны авлага бууруулах 153.4 сая нийт 879.8 сая төгрөгийн 5 алдааг залрууллаа.

5.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд авлага, орлого бүрэн тусгаагүй, мөнгөн хөрөнгө, үр дүн, төсвийн гүйцэтгэл зөрүүтэй илэрхийлэгдсэн байгаад дараах залруулга хийгдлээ. Үүнд:

5.1.1 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

- ✓ *Хүлээж аваагүй хөрөнгө оруулалтын санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй 273.0 сая, үр дүнгийн тайланд орлого бүртгээгүй 0.8 сая төгрөг, өмнөх оны мөнгөөр орж ирээгүй авлага залруулсан 153.4 сая, төсвийн гүйцэтгэлийн тайланд 431.3 сая, мөнгөн гүйлгээний тайланд 21.2 сая төгрөгийн орлого зөрүүтэй илэрхийлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.*

Аудитаар нийт 1341.3 сая төгрөгийн 4 зөрчил² илэрснээс 1244.2 сая төгрөгийн 3 зөрчилд 1 албан шаардлага бичиж, 97,1 сая төгрөгийн дахин давтан гаргахгүй байх 1 заалт бүхий зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт бичигдээгүй

5.3 Албан шаардлага

- ✓ *Хөшөөт хөгжил сангийн орлогын биелэлт тооцоогүй, Мон Эн Ко ХХК-тай хийсэн гэрээний биелэлт байхгүй, авлагын тооцоо хийгээгүй, ХХС-ийн журмын 3 дах заалтын хэрэгжилт хангалтгүй, банкнаас долларын ханшийн мэдээлэл авч ханшийн зөрүүг тухай бүр тооцож баталгаажуулаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт,*
- ✓ *Тайлант онд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй гэрээний биелэлт тооцож өглөг авлагын тооцоо хийж баталгаажуулаагүй, удирдах зөвлөлөөс хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд дотоод*

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан/, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- хяналт хэрэгжүүлээгүй, ХХС-ийн журмын 4 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй 260.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 10-р зүйлийн 10.1.7-д "төсвийн хэрэгжилтэд хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалт,
- ✓ Хөшөөт хөгжил сангийн хөрөнгийг олон нийтэд хүртээмжгүй, нийтийн эрх ашигт нийцээгүй урсгал зардалд зарцуулсан 984.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул албан шаардлага бичих

5.4 Зөвлөмж

5.4.1 Авлагатай холбоотой

Илрүүлэлт: Он дамжсан насжилт өндөртэй хөрөнгийн авлага буураагүй, өглөг авлагын тооцоо нийлж баталгаажуулаагүй 97.1 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Насжилт өндөртэй авлага бууруулж гэрээний үүргийн биелэлтийг тооцож тооцоо нийлсэн актаар баталгаажуулах

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/сая төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Дүн	Залруулаагүй	Дүн
Хүлээж аваагүй хөрөнгө оруулалтын санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй 273.0 сая, өмнөх оны мөнгөөр орж ирээгүй авлага өмнөх үр дүн рүү залруулсан 153.4 сая, төсвийн гүйцэтгэлийн тайланд 431.3 сая, мөнгөн гүйлгээний тайланд 21.2 сая төгрөгийн орлого залруулсан	5	879.8	-	-	5	879.8	5	879.8	-	-
Дүн	5	879.8	-	-	5	879.8	5	879.8	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөшөөт хөгжил сангийн орлогын биелэлт тооцрогуй, Мон Эн Ко ХХК-тай хийсэн гэрээний биелэлт байхгүй, орлого бүрэн төвлөрүүлээгүй, авлага тусгаагүй, ХХС-ийн журмын 3 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй, банкнаас долларын ханшийн мэдээлэл авч ханшийн зөрүүг тухай бүр тооцож баталгаажуулаагүй	-	-			-		-	-
Тайлант онд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй гэрээний биелэлт тооцож өглөг авлагын тооцоо хийж баталгаажуулаагүй, удирдах зөвлөлөөс хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, ХХС-ийн журмын 4 дэх заалтын хэрэгжилт хангалтгүй	1	260.0			1	260.0	-	-
Насжилт өндөртэй авлага өглөг бууруулаагүй, тооцоо хийж баталгаажуулаагүй	1	97.1					1	97.1
Дүн	2	357.1	-	-	1	260.0	1	97.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хөшөөт хөгжил сангийн хөрөнгийг олон нийтэд хүртээмжгүй, нийтийн эрх ашигт нийцээгүй урсгал зардалд зарцуулсан	1	984.2	-	-	1	984.2	-	-
Дүн	1	984.2			1	984.2		
Нийт дүн	1	984.2			1	984.2		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ





ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 04/АМБ 0/129

Ховд

ХОА-2022-/225/-НА-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөшөөт хөгжил сангийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд: Хөшөөт хөгжил сангийн орлогын гүйцэтгэл тооцоогүй, байгууллагаат хийсэн гэрээний биелэлт байхгүй, ХХС-ийн журмын 3 дах заалтын хэрэгжилт хангалтгүй хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй гэрээний биелэлт тооцож өглөг авлагын тооцоо хийж баталгаажуулаагүй, удирдах зөвлөлөөс хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, банкнаас долларын ханшийн мэдээлэл авч ханшийн зөрүүг тухай бүр тооцож баталгаажуулаагүйтэй холбоотой 260.0 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 10-р зүйлийн 10.1.7-д "төсвийн хэрэгжилтэд хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой орлогын гүйцэтгэлийн тооцоо хийж гэрээ дүгнэх, сангийн журмыг баримтлах, авлага, өглөг баталгаажуулах, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
3. Цаашид дээрх зөрчилтэй холбоотой алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлж хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөшөөт хөгжил сангийн дарга Т.Мягмардорж Нягтлан бодогч А.Хандмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ

¹ Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 сарын 22-дөр

Дугаар 28/А/2160/НЗ

Ховд

ХОА-2022-/225/-НА-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөшөөт хөгжил сангийн 2022 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөшөөт хөгжил сангийн хөрөнгийг олон нийтэд хүртээмжгүй, нийтийн эрх ашигт нийцээгүй урсгал зардалд зарцуулж дотоод хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой 984.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 10-р зүйлийн 10.1.7-д "төсвийн хэрэгжилтэд хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцээгүй

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах, сангийн журмыг баримтлах, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх.
3. Цаашид дээрх зөрчилтэй холбоотой алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, ажилтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлж хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөшөөт хөгжил сангийн дарга Т.Мягмардорж Нягтлан бодогч А.Хандмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ